# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 26 (359)

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:**

- *Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай*

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:**

- *Хэлэлцээр батлах тухай*
- *Хөрөнгө гаргах тухай*
- *Дэлхийн яруу найрагчдын XXVI их хурлын тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**

**Улаанбаатар хот**

**2004 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот    2004 оны долдугаар сарын 5    №26 (359)


## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 301. | ОХУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 93 | 636 |
| 302. | Ч. Элдэв-Очир, С. Амар нарыг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай | Дугаар 94 | 636 |
| 303. | Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай | Дугаар 95 | 636 |
| 304. | Зарим хүмүүсийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 96 | 638 |
| 305. | Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 97 | 638 |


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 306. | Хэлэлцээр батлах тухай | Дугаар 93 | 638 |
| 307. | Хэлэлцээр батлах тухай | Дугаар 94 | 639 |
| 308. | Хөрөнгө гаргах тухай | Дугаар 97 | 639 |
| 309. | Хэлэлцээрийг батлах тухай | Дугаар 100 | 639 |
| 310. | Хэлэлцээрийг батлах тухай | Дугаар 101 | 639 |
| 311. | Журамд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 102 | 640 |
| 312. | Малын гоц халдварт өвчний цагийн байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 104 | 640 |
| 313. | Дэлхийн яруу найрагчдын XXVI их хурлын тухай | Дугаар 107 | 640 |

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2004 оны 6 дугаар сарын 02-ны өдөр** **Дугаар 93** **Улаанбаатар хот**

**ОХУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай**

Монгол Улс, ОХУ-ын төмөр замын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх, монголын төмөр замыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын тээвэр холбооны болон төмөр замын байгууллагын дор дурдсан ажилтныг одон, медалиар шагнасугай.

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

Хасян Шарифжанович Зябиров -ОХУ-ын хувь нийлүүлсэн "Российские железные дороги" нийгэмлэгийн дэд ерөнхийлөгч

**"НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР:**

1. Сергей Алексеевич Аристов
ОХУ-ын Тээвэр, холбооны орлогч сайд

2. Александр Иванович Касьянов
Хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн ерөнхий хорооны дарга бөгөөд ОХУ-ын Дорнод Сибирийн төмөр замын дарга асан

3. Алексей Владимирович Грибанов
Хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн ерөнхий хорооны гишүүн

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2004 оны 6 дугаар сарын 03-ны өдөр** **Дугаар 94** **Улаанбаатар хот**

**Ч.Элдэв-Очир, С.Амар нарыг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон тул Чантуугийн Элдэв-Очирыг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Сүрэнхорын Амарыг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус огцруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2004 оны 6 дугаар сарын 04-ний өдөр** **Дугаар 95** **Улаанбаатар хот**

**Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын саналыг харгалзан ЗАРЛИГ болгох нь:

1.Хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад төрийн захиргааны тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэв олгосугай.

2.Энэхүү зарлигийг 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 06 дугаар сарын 04 -ний өдрийн 95 дугаар зарлигийн хавсралт*

**ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИД**

| № | Овог нэр | Албан тушаал | Албан тушаалын зэрэглэл | Албан тушаалын зэрэг дэв |
|---|---|---|---|---|
| 1. | Намсрайжавын Лувсанжав | УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | ТӨ-5 | Дэд |
| 2. | Баясгалангийн Ганбат | УИХ-ын Тамгын газрын нарийн бичгийн дарга | АА-1 | Гутгаар |
| 3. | Бэгзийн Очирбат | Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга | АА-1 | Тэргүүн |
| 4. | Самдангийн Цэдэндамба | Ерөнхийлөгчийн Тамгын газрын Зөвлөхүүдийн ажлын албаны дарга | АА-3 | Дэд |
| 5. | Шаравжамцын Бүүвээбаатар | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Зохион байгуулалтын хэлтсийн дарга | АА-3 | Дэд |
| 6. | Лувсангийн Ишдорж | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга | АА-3 | Дэд |
| 7. | Шилагарьдын Солонго | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хуулийн хэлтсийн дарга | АА-3 | Дэд |
| 8. | Цэрэндоржийн Содномпил | Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга | ТЗ-13 | Тэргүүн |
| 9. | Бөөрөнхийн Мишигжав | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга | ТЗ-13 | Тэргүүн |
| 10. | Самдангийн Дуламсүрэн | Эмнэлгийн тусламжийг удирдах газрын дарга | ТЗ-13 | Гутгаар |
| 11. | Жигмэдцэдэнгийн Хүрэлсүх | Стандартчилал, хэмжилзүйн төвийн дарга | ТЗ-13 | Гутгаар |
| 12. | Дугарын Жаргалсайхан | Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын дарга | ТЗ-13 | Гутгаар |
| 13. | Жамбалын Хатанбаатар | Улсын нийгмийн халамжийн газрын дарга | ТЗ-13 | Гутгаар |
| 14. | Чойжинжавын Сумаахүү | Нийслэлийн Засаг даргын орлогч | ТЗ-13 | Тэргүүн |

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2004 оны 6 дугаар сарын 04-ний өдөр** **Дугаар 96** **Улаанбаатар хот**

### Зарим хүмүүсийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хөхийсүрэнгийн Батсүрэн, Нэрэндашийн Дуламсүрэн, Авирмэдийн Отгонцэцэг, Цэндийн Цогт, Лувсандашийн Амарсанаа, Түндэвийн Энхмаа нарыг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2004 оны 6 дугаар сарын 04-ний өдөр** **Дугаар 97** **Улаанбаатар хот**

### Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөр ажил, албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Дамдинсүрэнгийн Оюунхүүг Архангай аймгийн шүүхийн шүүгчийн, Очирбатын Чулуунцэцэг, Минжүүрийн Жаргалсайхан нарыг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Зукарын Гульбаршаг Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Далантайн Нарантуяаг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Намсрайн Балжмаа, Довдонгийн Очмандах нарыг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Батбаярын Оюуныг Дорнод аймгийн Хэрлэн сумын шүүхийн шүүгчийн, Баярын Цэндийг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Адилбишийн Сайнтөгсийг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Буянтогтохын Сугиржав, Хумбаагийн Отгонжаргал нарыг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Доржийн Нямыг Завхан аймгийн шүүхийн шүүгчийн, Нямын Амарзаяаг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Балжирхүүгийн Энхтайваныг Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгчийн, Цэдэн-Ишийн Нэргүйг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Батжаргалын Батзоригийг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр** **Дугаар 93** **Улаанбаатар хот**

### Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2003 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Москва хотноо гарын үсэг зурсан "Олон улсын авто тээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр", 2004 оны 3 дугаар сарын 1-ний өдөр Бишкек хотноо гарын үсэг зурсан "Олон улсын авто тээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийг тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР**

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД БӨГӨӨД ДЭД БҮТЦИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ГАНЗОРИГ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр** **Дугаар 94** **Улаанбаатар хот**

**Хэлэлцээр батлах тухай**

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2004 оны 3 дугаар сарын 1-ний өдөр Бишкек хотноо гарын үсэг зурсан "Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийг батлалсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР**

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД БӨГӨӨД ДЭД БҮТЦИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ГАНЗОРИГ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 5 дугаар сарын 5-ны өдөр** **Дугаар 97** **Улаанбаатар хот**

**Хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр БНАСАУ-ын Рёнчений галт тэрэгний буудалд осол гарч олон хүн эрсдэж шархадсантай холбогдуулан үзүүлэх хүмүүнлэгийн тусламжид зориулан 10.0 (арван) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР**

**САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 5 дугаар сарын 5-ны өдөр** **Дугаар 100** **Улаанбаатар хот**

**Хэлэлцээрийг батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2003 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр гарын үсэг зурсан "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Израиль Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийг батлалсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР**

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 5 дугаар сарын 5-ны өдөр** **Дугаар 101** **Улаанбаатар хот**

**Хэлэлцээрийг батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2003 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Пхеньян хотноо гарын үсэг зурсан "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийг батлалсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР**

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 5 -ны өдөр | Дугаар 102 | Улаанбаатар хот

### Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Журам батлах тухай" Засгийн газрын 2002 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам, магадлан шинжлэх ажлын шалгуур"-ын 7 дугаар заалтын "... авч ..." гэснийг "... авсан..." гэж өөрчилж, мөн заалтын "...3-аас дээш жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан ..." гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** Н.ЭНХБАЯР

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД** П.НЯМДАВАА

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 5 -ны өдөр | Дугаар 104 | Улаанбаатар хот

### Малын гоц халдварт өвчний цагийн байдалтай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Сүхбаатар, Дундговь аймгийн зарим сумын нутагт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний голомтыг устгах арга хэмжээ болон халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын үр дүн, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, Гамшигтай тэмцэх комиссын хуралдааны шийдвэрийг харгалзан Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Наран сумын нутаг дэвсгэрт тогтоосон хорио цээрийн онцгой дэглэм, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулж 5 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн хорио цээрийн хязгаарлалтын дэглэм тогтоон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг дэвсгэрт тогтоосон хорио цээрийн онцгой дэглэм, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг болон Дундговь аймгийн Баянжаргалан, Өндөршил, Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Уулбаян, Халзан, Дарьганга сумын нутагт тогтоосон хорио цээрийн хязгаарлалтын дэглэм, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг 2004 оны 5 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн цуцалсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Малын гоц халдварт шүлхий өвчний талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 65 дугаар тогтоолын 1, 2 дугаар зүйл, "Хорио цээрийн дэглэм, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг бууруулах, цуцлах тухай" Засгийн газрын 2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 90 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** Н.ЭНХБАЯР

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД** Д.НАСАНЖАРГАЛ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 5 -ны өдөр | Дугаар 107 | Улаанбаатар хот

### Дэлхийн яруу найрагчдын XXYI их хурлын тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дэлхийн яруу найрагчдын XXYI их хурлыг 2006 онд Монголын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын ивээл дор зохион байгуулах Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны саналыг зүйтэй гэж үзсүгэй.

2. Дэлхийн яруу найрагчдын XXYI их хурлыг зохион байгуулах үндэсний хороог 1 дүгээр, ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. Их хурлыг зохион байгуулах бэлтгэлийг хангаж, уг арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил жилийн төсөвт тусган санхүүжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** Н.ЭНХБАЯР

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД** А.ЦАНЖИД

*Засгийн газрын 2004 оны 107 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт*

## ДЭЛХИЙН ЯРУУ НАЙРАГЧДЫН XXYI ИХ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРОО

| | |
|---|---|
| Дарга | -Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд |
| Ерөнхий зохицуулагч | -Дэлхийн яруу найрагчдын XXYI их хурлыг зохион байгуулах Олон улсын хорооны дарга |
| Гишүүд: | -Гадаад хэргийн дэд сайд;<br>-Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Аялал жуулчлалын газрын дарга;<br>-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн бодлого, зохицуулалтын газрын дарга;<br>-Нийслэлийн Засаг даргын орлогч;<br>-Монголын зохиолчдын эвлэлийн удирдах зөвлөлийн дарга (тохиролцсоноор);<br>-Монголын Үндэсний Чөлөөт зохиолчдын холбооны тэргүүн (тохиролцсоноор);<br>-Төв аймгийн Засаг даргын орлогч;<br>-ЮНЕСКО-гийн үндэсний комиссын ерөнхий нарийн бичгийн дарга;<br>-Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн дэд захирал;<br>-Чингис хааны 840, Монгол тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулах хорооны ерөнхий зохицуулагч. |

*Засгийн газрын 2004 оны 107 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт*

## ДЭЛХИЙН ЯРУУ НАЙРАГЧДЫН XXYI ИХ ХУРЛЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2004 он

| | Ажлын төлөвлөгөө | Хугацаа |
|---|---|---|
| 1 | Монголын яруу найргийг гадаадад сурталчлах үндэсний сэтгүүл хэвлэх ажлыг эхлүүлж, анхны хоёр дугаарыг бэлтгэж гадаадын утга зохиол, яруу найргийн байгууллагуудад тараах | ҮШ сар |
| 2 | Дэлхийн шилдэг яруу найраг-10 боть номыг хэвлүүлэх бэлтгэл ажлыг хангаж эхний 4 ботийг хэвлэх | ХП сар |
| 3 | Монголын яруу найргийг англи хэлээр орчуулах төсөл сонгон шалгаруулах | Ш улирал |
| 4 | Монголын шилдэг яруу найргийг VCD-гээр хэвлүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлж эхлэх | Ш улирал |

2005 он

| | Ажлын төлөвлөгөө | Хугацаа |
|---|---|---|
| 1 | Дэлхийн шилдэг яруу найраг 4 боть хэвлүүлэх | I-YI сар |
| 2 | "Монголын яруу найраг" ВЭБ хуудас нээх | I сар |
| 3 | Монголын шилдэг яруу найргийг VCD-гээр хэвлүүлэх | П сар |
| 4 | XXI зууны "Монголын шилдэг яруу найраг" анталоги семинар зохион байгуулах | П сар |
| 5 | "Монголын яруу найргийн XXI зууны төлөв" үндэсний семинар зохион байгуулах | ХП сар |

| | | |
|---|---|---|
| 6 | Монголын яруу найргийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах үндэстний өдөрлөгүүд зохион байгуулах | Ш, Х, ХП сар |
| 7 | Монголын яруу найргийн сэтгүүлийг гадаад хэл дээр хэвлэж тараах | I, YI сар |
| 8 | Дэлхийн яруу найрагчдын их хурлын сан бүрдүүлэх арга хэмжээнүүд зохион байгуулах | Ш, Х сар |
| 9 | Дэлхийн яруу найрагчдын их хурлын зочдыг хүлээн авч үйлчлэх, аяллын хөтөлбөр зохион байгуулах тендерийг аялал жуулчлалын байгууллагуудын дунд зарлах | Ш, Х сар |

2006 он

| | Ажлын төлөвлөгөө | Хугацаа |
|---|---|---|
| 1 | Монгол орон, Монголын түүх, соёл, нүүдлийн соёл иргэншлийн язгуур өв уламжлалыг дээдэлсэн яруу найргийн уралдаан зохион байгуулах | Х сар |
| 2 | Яруу найргийн уулзалт үдэшлэг, яруу найргийг сурталчлах хөтөлбөрүүд хэрэгжүүлэх | Ш, YI, YШ сар |
| 3 | Дэлхийн шилдэг яруу найргийн номын баяр хийх | YШ сар |
| 4 | Дэлхийн яруу найрагчдын их хурлыг угтсан сурталчилгааны өдөрлөгүүд зохион байгуулах | YI, YШ сар |
| 5 | Монголын уран зохиолчдын уран бүтээлийн отог (номын хүрээ)-ийг байгуулж эхлэх | Y сар |
| 6 | Монголын яруу найргийг CD, VCD, DVD хэвлүүлж дэлгэрүүлэх | П сар |
| 7 | Яруу найргийн шилдэг бүтээлийн (англи, монгол хэл дээр) анталоги хэвлүүлэх (шилдэг орчуулга, шилдэг судлал шүүмжийн бүтээл хамаарна) | YI сар |
| 8 | Монголын утга зохиолыг сурталчлах сурталчилгааны материал хэвлүүлж тараах | Ш сар |
| 9 | Дэлхийн яруу найрагчдын XXYI их хурлыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион явуулах | YП, IX сар |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**"Төрийн Мэдээлэл"** эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12,
Төрийн ордон
☎ 329612 Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 1